



Хавтсанд:

Компаниас зарласан гар зургийн
уралдаанд тэргүүн байр эзэлсэн
Т.Хатанзаяа (8 нас)-гийн бүтээл.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН 2021

I. КОМПАНИЙН ТУХАЙ

II. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

III. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

IV. ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА

V. АЖИЛЛАГСАД

VI. БАЙГАЛЬ ОРЧИН

VII. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

VIII. ШИНЭ ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ

I. КОМПАНИЙН ТУХАЙ

Энержи Ресурс компани нь 2005 онд байгуулагдсан үндэсний уул уурхайн компани бөгөөд 2009 оноос хойш Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа худаг нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулдаг.

Бид нэмүү өртөг шингэсэн, сайн чанарын коксжих нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөн, Монгол Улсын хөгжил, дэвшил, үйлдвэржилтэд бодитой хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар шууд ба шууд бусаар нийт 2,500 орчим хүнийг ажлын байраар хангахын зэрэгцээ үндэсний 2,000 гаруй аж ахуйн нэгжтэй урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн, татвар төлөлт, нийгмийн хариуцлагаар Монгол Улсын ТОП 5 компанийн жагсаалтанд сүүлийн арав гаруй жил тасралтгүй бичигдэж байгаа, хувийн хэвшлийн тэргүүлэгч аж ахуйн нэгж билээ.

Бид 2008 оноос Ухаа худагийн хөндийд томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлж эхэлсэн. Алслагдсан говь нутагт маш богино хугацаанд Монгол инженер, техникийн ажилтнуудын хамтын хүчээр Монголын анхны Нүүрс баяжуулах үйлдвэр болон 18 мегаваттын цахилгаан станц, хатуу хучилттай авто зам, усан хангамжийн систем, 650 айлын орон сууцны хороолол, 1,000 гаруй хүүхдийн багтаамжтай сургууль, цэцэрлэгийн цогцолбор зэрэг дэд бүтцийн томоохон байгууламжуудыг барьж ашиглалтад оруулан, дэлхийн жишигт нийцсэн, уул уурхайн цогцолборыг бий болгосон.

2010 онд Монголын үндэсний компаниудаас анх удаа Хонконгийн хөрөнгийн биржид амжилттай IPO хийж, олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргасан нээлттэй хувьцаат компани бөгөөд хувьцааны хяналтын багцыг үндэсний хөрөнгө оруулагчид эзэмшдэг.

Нээлттэй хувьцаат компани гэдэг утгаараа компанийн нийгмийн хариуцлага (КНХ)-ыг анхнаас нь бодитой, зөв хэрэгжүүлэхэд анхаарч бодлого чиглэлээ олон улсын КНХ-ын сайн дурын стандарт ISO:26000-д нийцүүлэн боловсруулсан. Нийгмийн хариуцлага, байгаль орчин, нөхөн сэргээлтийн бодлого болон орон нутгийн тогтвортой хөгжилд оруулах бидний хувь нэмэр компанийн урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй салшгүй холбоотой байдаг.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн техник, технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

АЛСЫН ХАРАА

Бид олон улсын зах зээл дээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно.

₮1.4

(2009-2021)
ИХ НАЯД

ТАТВАР ТӨЛӨЛТ

₮6.6

(2009-2021)
ИХ НАЯД

ДОТООДЫН
ХУДАЛДАН АВАЛТ

\$1.4

(2009-2021) ТЭРБУМ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1,880

ҮНДСЭН АЖИЛЛАГСАД

\$4.2

(2009-2021) ТЭРБУМ
ЭКСПОРТ

2,509

ШУУД БА ШУУД БУС
АЖЛЫН БАЙР



Ухаа худаг дахь Монголын анхны Нүүрс баяжуулах үйлдвэр

II. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ҮНЭТ ЗҮЙЛ

Компанийн сайн засаглал нь Энержи Ресурс ХХК-ийг ажиллуулах, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх үзэл баримтлал гэж бид үздэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөнө.

Бид компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх нь дэлхийн жишигт нийцсэн уул уурхайн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулан, нүүрсний салбарт улсдаа тэргүүлэгч аж ахуйн нэгж байх гол тулгуур хүчин зүйл гэж үздэг.

Иймд тус компани нь дотоодын болон олон улсын хэмжээнд мөрдөгддөг, сайн засаглалын шаардлагуудыг биелүүлэн ажилладаг төдийгүй нээлттэй, ил тод, хариуцлагатай байдал, шийдвэр гаргалтын энгийн, түргэн шуурхай орчныг бүрдүүлэхүйц байдлаар дотоодын дүрэм, журмуудынхаа хэрэгжилтийг ханган ажилладаг.

ЗАСАГЛАЛ, ИЛ ТОД БАЙДАЛ

Бид "ISO 26000: Нийгмийн хариуцлагын зөвлөмж" болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн Тогтвортой хөгжлийн бодлого болон Компанийн Нийгмийн Хариуцлагын бодлогоо 2011 онд боловсруулан батлуулж, компанийн бүх салбар болон охин компаниудад танилцуулан, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсээр ирлээ.

Компанийн хувь нийлүүлэгчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) болон гүйцэтгэх удирдлага нь Компанийн эрхэм зорилго, алсын хараа, эрхэм зүйлс, зорилтуудад компанийн сайн засаглалын олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөх талаар тусгаж баталгаажуулсан.

2019 онд компанийн ТУЗ-ийн дэргэд Байгаль орчин, нийгэм, засаглалын асуудал хариуцсан тусгай дэд хороо байгуулагдсан бөгөөд ингэснээр КНХ, байгаль орчин, засаглалын бодлого, стратеги чиглэлүүд, тухайн оны ажлын төлөвлөгөө ТУЗ-ийн түвшинд хянагдан, батлагдаж байна. Мөн КНХ-ын чиглэлд аливаа эрсдэл, алдаа дутагдал үүссэн тохиолдолд ТУЗ-өөс санал зөвлөмж өгөх, ахиц сайжралт гаргах, хяналт тавих боломж бүрдэж байна.

Түүнчлэн компанийн үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн, эрсдэлийн удирдлага, засаглал ба дотоод хяналтын үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэх хараат бус, бодитой баталгаа өгөх, зөвлөх зорилгоор Дотоод аудитын албыг 2013 оноос байгуулан ажиллаж байна.

Бид оролцогч, сонирхогч талуудын итгэлийг хүлээх үүднээс үйл ажиллагаагаа олон нийт, хөрөнгө оруулагчид болон бусад төр засаг, олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нээлттэй тайлагнасаар ирсэн. 2009 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС)-д нэгдэн, төр засгийн байгууллагад төлсөн төлбөр, татвар хураамжаа жил бүр ил тод, нээлттэй тайлагнаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйлсэд нэгдэн ажиллаж байна.

Монголын уул уурхайн ассоциаци, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хамтран санаачилсан "Хариуцлагаар нэгд" аянд нэгдэж "Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс"-ын харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Мөн тус компани нь "Өмнийн говийн усны менежементийн Сайн дурын кодекс"-ын гишүүн бөгөөд усны хэмнэлт, дахин ашиглалтын мэдээллээ сайн дураар тайлагнадаг.

ЁСЗҮЙ, ХҮНИЙ ЭРХ

Компанийн Ёсзүйн код нь ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт, ашиг сонирхлын зөрчил, авилгал хээл хахууль зэрэг зүй зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллагсад удирдамж, зааварчилгаа болдог. Энэхүү Ёсзүйн кодын хүрээнд ажиллагсад болон бусад оролцогч талууд бизнесийн ёс зүйн өндөр стандартыг баримтлан ажиллаж бүхий л төрлийн зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх улмаар таслан зогсоохыг эрмэлздэг.

Бид хүний эрхийг дээдэлж, үйл ажиллагааныхаа хүрээнд орон нутгийн иргэдийн болон ажиллагсдынхаа эрхийг зөрчихгүй байх талаар анхаарч ажилладаг төдийгүй хүний эрхийн эрсдлийн үнэлгээг хийж, түүний дагуу хөтөлбөр боловсруулж, сургалт зааварчилгааг холбогдох ажиллагсаддаа тогтмол өгдөг. Тухайлбал, Ухаа худаг төслийн хүрээнд шинээр ажилд орсон ажилтнуудад Ёсзүйн код, хүний эрхийн журмыг заавал танилцуулахаас гадна жил бүр бүх ажиллагсдыг хүний эрхийн сургалтад давтан хамруулдаг.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон, ажлын байрны дарамтнаас ангид нөхцлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн даатгалд даатгуулах зэрэг үндсэн заалтуудыг чандлан мөрдөж байна.

Мөн насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийн аливаа хэлбэрүүдийг үл тэвчих зарчим баримтлан холбогдох дотоодын дүрэм журам болон олон улсын конвенц, хууль дүрмүүдийг мөрдлөг болгон ирсэн.

III. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Уурхайчдын "Цэций" хороолол, Өмнөговь аймгийн Цогтцэций сум

ҮНЭТ ЗҮЙЛ

Бид нийгмийн хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй "сайн хөрш"-ийн харилцааг хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь иргэдэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

БОДЛОГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Бид компанийн нийгмийн хариуцлага гэх ойлголтыг нэг удаагийн хандив, тусламж эсхүл богино хугацааны төсөл, хөтөлбөрүүд гэх мэт хязгаарлагдмал хүрээнд авч үздэггүй. Харин олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд урт хугацааны, бодитой хувь нэмэр оруулж, тогтвортой хөгжлийн бат бэх суурь бий болгохыг зорьдог.

Энэ утгаараа Олон Улсын Стандартын Байгууллагаас 2010 онд гаргасан ISO 26000: Нийгмийн хариуцлагын зөвлөмж болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн Тогтвортой хөгжлийн болон КНХ-ын бодлогоо боловсруулж, үйл ажиллагаандаа тусгаж ирсэн. Энэхүү бодлогод дараах үндсэн чиглэлүүдийг тусгасан. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөө
- Хөдөлмөрийн харилцаа
- Байгаль орчин
- Бизнесийн шударга харилцаа
- Орон нутгийн оролцоо ба хөгжил

Уг бодлогод "Энержи Ресурс компани нь Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулахдаа КНХ-ын тухай олон улсын стандарт, олон улсын санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны шаардлагууд болон Монгол Улсын холбогдох стандарт, зарчмуудыг хүлээн зөвшөөрч, тэдгээрт нийцүүлсэн үйл ажиллагааг нээлттэй, ил тод явуулж, хүний эрх, хөдөлмөрийн шударга харилцаа, бизнесийн ёс зүйг дээдлэн хэрэгжүүлнэ" хэмээн заасан.

Компанийн зүгээс хийж хэрэгжүүлж буй төсөл, үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийж төслийн сонирхогч талууд болон олон нийтэд танилцуулдаг. Энэхүү үнэлгээний төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжүүлэлтийн явцад эерэг нөлөөллийг дэмжин, сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дараах төлөвлөгөөний дагуу тодорхой шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн.

- Төслийн сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө
- Олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээлэл түгээх төлөвлөгөө
- Байгаль орчин нийгмийн менежментийн төлөвлөгөө
- Өргөдөл гомдол барагдуулах журам
- Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө
- Олон нийтийн эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын төлөвлөгөө
- Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө гэх мэт.

Эдгээр төлөвлөгөөний дагуу хийсэн ажлуудаа хөрөнгө оруулагч болон олон нийтэд тогтмол тайлагнах үүрэг хүлээдэг. Мөн компанийн байгаль орчин, нийгэм, засаглалын бүхий л үзүүлэлт, үйл ажиллагаануудыг Нэгдсэн Үндэсний Байгууллагаас батлан гаргасан Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан нийцүүлэх зарчмаар ажиллаж байна.

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд төслийн үндсэн үйл ажиллагаа хэрэгждэг тул орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, нийгмийн суурь бүтцүүдийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, боловсролыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, жижиг дунд бизнесийг дэмжих үндсэн чиглэлүүдээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажилладаг.

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Энержи Ресурс компани нь үйл ажиллагаа эхлүүлснээс хойш татвар төлөлт, эдийн засагт оруулж буй хувь нэмрийн хэмжээгээр Монгол Улсын Топ 5 аж ахуйн нэгжээр тогтмол шалгарч, улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтөнд бодит хувь нэмрээ оруулсаар ирсэн.

2009 онд үүсэн байгуулагдсан цагаасаа хойш компани нийт нэг 1.4 тэрбум орчим долларыг уурхайн болон дагалдах дэд бүтцийн төслүүдийн хөрөнгө оруулалтанд зарцуулсан төдийгүй улс, орон нутгийн төсөвт татвар, хураамж хэлбэрээр 1.4 их наяд орчим төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацаанд улс орон даяар цар тахлын нөхцөл байдалтай, хилийн боомт, экспорт зогсонги, үйл ажиллагааны хүндрэлтэй байсан хэдий ч Энержи Ресурс компани ажиллагсдынхаа ажлын байрыг бүрэн хадгалснаас гадна 2021 онд нийт 132 тэрбум төгрөгийг улсад татвар, шимтгэл хэлбэрээр төвлөрүүлжээ.

Энержи Ресурс компани нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд дотоодын нийт 2,000 гаруй аж ахуйн нэгжтэй бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч хэлбэрээр урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн. Зөвхөн 2021 оны байдлаар бид нийт 430 гаруй аж ахуйн нэгжээс 629 тэрбум төгрөгийн хэрэгцээт бараа, үйлчилгээг худалдан авсны 80 гаруй хувь нь дотоодын аж ахуйн нэгж, компаниуд байлаа.

Мөн тайлант онд бид ажиллагсдын цалин урамшуулалд нийт 68 орчим тэрбум төгрөгийг олгосон байна.

ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Энержи Ресурс компаниас нийгэм, орон нутагт чиглэсэн, урт хугацааны үр өгөөжтэй төсөл, хөтөлбөрүүдийг оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлсээр ирсэн. Үүсэн байгуулагдсан цагаас хойш өнөөдрийг хүртэлх арав гаруй жилийн хугацаанд:

- Орон нутгийн боловсролыг дэмжих
- Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих
- Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах
- Соёлын өвийг хамгаалах
- Ажлын байрыг нэмэгдүүлэх
- Байгаль орчныг хамгаалах

гэсэн үндсэн чиглэлүүдээр нийгмийн хариуцлагын нийт 50 гаруй бие даасан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирлээ.

2021 оны хувьд Өмнөговь аймагт хэрэгжүүлдэг орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдээсээ гадна үндэсний хэмжээний нийгмийн сайн сайхны төлөөх сайн дурын үйлсэд бодит хувь нэмрээ оруулах төсөл, ивээн тэтгэлгүүдийг үргэлжлүүлэн “Говийн уурхайчид”, “Цэцийн өнгө”, “Амжилтын томъёо”, “Энержи 3x3 сагсан бөмбөгийн клуб”, “Монголын 3x3 сагсан бөмбөгийн холбоо”, “Монголын уул уурхайн сургалт судалгааны төв”, “Та Монгол ээж” ТББ зэрэг нийт 10 орчим ТББ-уудтай хамтарч ажилласан байна.

“Цэвэр агаар” төслийн дэмжигч

Улаанбаатарын утааг бууруулах, түүхий нүүрсний хэрэглээг халж, сайжруулсан шахмал түлшээр бүрэн хангах Монгол Улсын Засгийн газрын үйлсэд хувь нэмрээ оруулан, шахмал түлшний үндсэн түүхий эд болох баяжуулсан эрчим хүчний нүүрсийг төрийн өмчит “Тавантолгой түлш” компанид 2018 оноос хойш үнэ төлбөргүй нийлүүлж байна.

Энэ ажлын хүрээнд одоогийн байдлаар нийт 40 орчим тэрбум төгрөгийн үнэ бүхий 1.7 сая тн баяжуулсан эрчим хүчний нүүрс нийлүүлээд байна. Монгол Улсын Засгийн газраас гаргасан судалгаа, мэдээллүүдэд Улаанбаатар хотын агаарын бохирдлын түвшинг сүүлийн гурван жилд ойролцоогоор 40 хувиар буурсан болохыг онцолжээ.



3X3 САГСНЫ ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГУУДЫН АЛБАН ЁСНЫ ТҮНШ

Монгол Улсад багийн спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Энержи Ресурс компани 3x3 сагсан бөмбөгийн үндэсний шигшээ багуудын албан ёсны түншээр гуравдахь жилдээ ажиллаж байна.

Энэ хүрээнд Монголдоо анх удаа “Энержи 3x3” мэргэжлийн клубыг байгуулан, шигшээ багуудын байнгын бэлтгэл сургуулилт, бүс нутаг, тив дэлхийн тэмцээнүүд болон Олимпын наадамд оролцох бүх боломжийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд одоогоор тус клубт мэргэжлийн нийт долоон баг харьяалагдаж байна. Хамгийн чухал нь, багийн спортоор шинэ залуу тамирчид төрөн гарах, гадаад, дотоодод өрсөлдөх боломжийг өргөжүүлж өгч буйгаараа ач холбогдолтой юм.

IV. ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА



₮9.5
(2021) **ТЭРБУМ**

ОРОН НУТГИЙН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

₮4.8
(2021) **ТЭРБУМ**

ОРОН НУТГИЙН
ХУДАЛДАН АВАЛТ

40%
(2021)

ОРОН НУТГИЙН
АЖИЛЛАГСАД

"Ухаа худаг" наадмын үеэр, 2019 он

БОДЛОГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Бид үүсэн байгуулагдсан цагаасаа хойш орон нутгийн иргэдтэй сайн хөршийн харилцааг хөгжүүлж, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар олон нийтийн санал бодлыг төсөл хэрэгжилтийн явцад тусгаж ирсэн бөгөөд жил бүр хамгийн багадаа нэг тэрбум гаруй төгрөгийг орон нутгийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулсаар ирсэн.

Энержи Ресурс компани нь төслийн үйл ажиллагаандаа оролцогч, сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг 2009 оноос эхлэн урт хугацаанд тогтвортойгоор хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төлөвлөгөөний дагуу дараах зарчмуудыг ханган ажилладаг.

- Иргэд, олон нийтийг компанийн үйл ажиллагааны талаар холбогдох мэдээлэл авах эрхийг бүхий л талаар ханган ажиллах;
- Олон нийтийн иргэдийн санал хүсэлтийг "Нээлттэй өдөрлөг" хийх замаар үйл ажиллагаандаа тогтмол тусгах;
- Орон нутгийн иргэдийн оролцоог хангах замаар төрөл бүрийн хэлэлцүүлэг, бүлгийн уулзалт, сайн дурын зөвлөлийг дэмжин ажиллах;
- Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн зорилтот төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;
- Иргэдийн санал, хүсэлт болон өргөдөл гомдлыг мэдээллийн төв болон бусад сувгаар тогтмол хүлээн авах;

Орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдад орон нутгийн сайн дурын зөвлөл (ОНЗ) байгуулан тууштай хамтран ажилласаар ирсэн. ОНЗ нь орон нутгийн иргэдийн шууд дуу хоолойг сонсох үндсэн зорилготой бөгөөд тухайн сумдын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, олон хүүхэдтэй эмэгтэйчүүд, ахмад настнууд, төрийн албан хаагчид гэх мэт бүх талын төлөөллүүдийг аль болох багтаасан байдаг.

Түүнчлэн орон нутгийн иргэдийг байгаль орчны мониторинг, гар худаг болон тоосны хэмжилт, нөхөн сэргээлтийн ажилд сайн дураараа хяналт тавих байдлаар тогтмол оролцуулдаг нь компани ба иргэд хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлдөг.

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ

Орон нутгийн иргэд болон ажиллагсдаас ирсэн гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэн эргэн мэдээлэх "Иргэд, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журам" хэрэгжүүлэн ажилладаг. Ингэхдээ

өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариу өгч, шаардлагатай болон хүсэлт гаргасан тохиолдолд гомдлын нууцлалыг хадгалах ба бүх гомдолд ижил тэгш зарчмаар ханддаг.

2021 онд нийт 24 өргөдөл, хүсэлт хүлээн авч, хүсэлтүүдийг 100 хувь шийдвэрлэсэн байна. Нийт хүлээн авсан өргөдлүүдээс санхүүгийн дэмжлэг хүссэн хоёр өргөдөлд татгалзсан хариу өгсөн. Өргөдлүүдэд компаниас хэрэгжүүлж

Өргөдөл, хүсэлтийн ангилал



буй төсөл, хөтөлбөр, сургалтад хамрагдах, хамтран ажиллах мөн санхүүгийн болон биет дэмжлэг хүссэн, утгатай хүсэлтүүд зонхилж байсан. Тайлант хугацаанд шаардлага, гомдол хүлээж аваагүй. Компанийн зүгээс хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бодитой хэрэгжүүлж, нээлттэй, олон талт харилцааг хөгжүүлэн ажиллаж ирсний үр дүнд сүүлийн жилүүдэд иргэдийн шаардлага, гомдлын тоо багасч, харин хамтын ажиллагааны санал хүсэлтийн тоо эрс нэмэгдэж байна.

ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Орон нутгийн тогтвортой хөгжлийн чухал хөшүүргүүдийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Энержи Ресурс компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш төвөөс алслагдсан бүс болох Өмнөговь аймгийн Цогтцэций сум буюу Ухаа худагийн хөндийд өргөн цар хүрээтэй бүтээн байгуулалтыг өрнүүлж, уурхай дагасан дэд бүтцийн шийдлийг цогцоор бүрдүүлсэн.

Тухайлбал, Монгол инженерүүдийн ур ухаанаар дулааны цахилгаан станц, усан хангамжийн систем барьж байгуулснаар орон нутгийн иргэд 24 цагийн найдвартай эрчим хүч, цэвэршүүлсэн усаар хангагдах болсон.

Орон нутгийн хөрөнгө оруулалт 2021	(төгрөг)
Орон нутгийн дэд бүтэц	3,153,200,000
Ус хангамж	1,803,200,000
Ус цэвэршүүлэх байгууламж	1,350,000,00
Орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд	194,450,000
Боловсролыг дэмжих хөтөлбөр	59,450,000
Байгаль орчныг дэмжих хөтөлбөр	131,000,000
Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр	4,000,000
Хандив, тусламж (Өмнөговь)	1,318,293,000
Ковид-19 хандив (түргэвчилсэн оношлуур, эмнэлгийн ор)	46,900,000
Орон нутгийн ТББ-уудын хамтын ажиллагаа	96,000,000
Нүүрсний дэмжлэг	1,012,000,000
"Сайн хөрш" хөтөлбөр	163,393,000
Орон нутгийн худалдан авалт	4,800,000,000
Нийт	9,465,943,000


Мөн 650 айлын, орон сууцны "Цэций" хороолол, сургууль цэцэрлэгийн "Мөрөөдөл" цогцолборыг барьж байгуулснаар ажиллагсад болон орон нутгийн иргэд ая тухтай амьдрах, хүүхэд багачууд говийн алслагдмал суманд ч тохилог орчинд, чанартай боловсрол олж авах нөхцөл боломж бүрдсэн. Тайлант онд нийт 9.5 тэрбум төгрөгийг орон нутгийн дэд бүтэц, тогтвортой хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөр болон орон нутгийн худалдан авалт, хандив тусламжид зарцуулсан байна.

Орон нутгийн тогтвортой хөгжил, эдийн засгийг дэмжих нэг хэлбэр нь орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс бараа бүтээгдэхүүн худалдан авах явдал байдаг. Компанийн зүгээс бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа бизнесийн шударга зарчмыг баримталж, орон нутгийн бизнес эрхлэгчдэд аль болох давуу эрх олгож, хамтран ажиллахыг нэн тэргүүнд зорьдог.

Өмнөговь аймгийн хэмжээнд 2021 онд орон нутгийн 20 аж ахуйн нэгжээс нийт 4.8 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн нь өнгөрсөн 2020 оноос даруй нэг тэрбум гаруй төгрөгөөр өссөн үзүүлэлт болжээ. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүүгүй зээл олгосоор байна.

Манай нийт ажиллагсдын 40 орчим хувь нь орон нутгийн иргэд байдаг тул ажиллагсдын цалин урамшуулал, нийгмийн хангамжаар дамжин сум орон нутгийн эдийн засагт томоохон нөлөөтэй байдаг. Тухайлбал, зөвхөн орон нутгийн ажиллагсдын цалин, урамшуулалд жил тутам 20 орчим тэрбум төгрөг зарцуулдаг.

Худалдан авалт (тэрбум төгрөг)



АМЖИЛТЫН ТҮҮХ

М.Должин нь нөхөр, хүүхдүүдийн хамт нийслэлээс 2018 онд Цогтцэций суманд шилжиж ирсэн. Тэрбээр уламжлалт анагаах ухааны их эмч мэргэжилтэй тул 2019 онд өөрийн хувийн эмнэлгээ нээж "Цэций" хорооллын 2-р байранд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Тэрбээр бизнесээ эхлүүлэхийн тулд Энержи Ресурс компаниас хэрэгжүүлдэг жижиг дунд бизнесийг дэмжих "Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр" -т хамрагдан хүүгүй зээл авсан.

Ингэснээр уурхайчид, тэдний гэр бүлийнхэн, орон нутгийн иргэд тус эмнэлгээр идэвхитэй үйлчлүүлэх болж, улмаар 2021 онд нэг хүнийг нэмж ажилд авч ажлын байраар ханган үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Цогтцэций суманд хүн амын төвлөрөл ихтэй, эмнэлэгүүдийн ачаалал ихтэй байдаг. Ялангуяа сүүлийн жилүүдэд тохиосон цар тахлын хүнд цаг үед улсын эмнэлгийн ачааллыг үүрэлцэж, олон хүний эрүүл мэндэд тустай үйл ажиллагаа явуулж сум, орон нутгийн эрүүл мэндийн салбарт багагүй хувь нэмэр оруулж байна.



ОРОН НУТГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг 2013 оноос хойш үе шаттай хэрэгжүүлж, 2019 оноос эхлэн шинэчилсэн хэлбэрээр үргэлжлүүлж байна. Цогтцэций сумын ерөнхий боловсролын хоёр сургуулийн нийт 2,000 гаруй сурагчийг хамардаг уг хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатараас чадварлаг багш, зөвлөхүүдийг Цогтцэцийд гэрээгээр ажиллуулах, хүүхэд бүрт хүртээмжтэй математикийн онлайн хөтөлбөр нэвтрүүлэх, багш нарт гүйцэтгэл, үр дүнгийн урамшуулал олгох зэрэг ажлууд хийгдэж ирсэн.

Үүний үр дүнд сүүлийн жилүүдэд Цогтцэций сумын 2-р сургууль нь аймагтаа чанараар тэргүүлдэг төдийгүй төгсөгчдийн чанараар улсын дунджаас дээгүүр бичигдэх болсон. Тайлант онд Ковид-19 цар тахлын улмаас сурагчид хичээлээ зайнаас болон цахимаар үзэх болсонтой холбогдуулан “Сураад” математикийн онлайн хөтөлбөрөө улам идэвхжүүлэн хүүхэд нэг бүрт хүргэх, багш нараас онлайнгаар зөвлөгөө, давтлага авах цагийг нэмэгдүүлэх зэргээр ажиллалаа.

Одоогоор тус хөтөлбөрийн “Сураад” математикийн онлайн програмд дээрхи сургуулиудын 5-11-р ангийн 650 сурагч хамрагдаж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРСНИЙ ХАНГАЛТ

Өмнөговь аймаг болон ойролцоох сумдын өвөлжилтийн хэрэгцээнд зориулан жил бүр эрчим хүчний нүүрсээр ханган ажиллаж байна. Тодруулбал, 2009 оноос хойш Даланзадгадын дулааны цахилгаан станц, Цогтцэций, Баян-Овоо, Булган, Хүрмэн, Мандал-Овоо, Манлай, Номгон, Ханбогд, Цогт-Овоо, Сэврэй, Ханхонгор сумдын эрчим хүч болон албан газруудын хэрэгцээний нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлсээр ирсэн. 2021 онд дээрх газруудад нийт 470 сая төгрөгийн өртөг бүхий 1,800 тн угааж баяжуулсан нүүрс, 12,500 тн түүхий нүүрсийг тус тус үнэ төлбөргүй нийлүүлсэн байна.

Цогтцэций сумын агаарын бохирдол, утааг бууруулах ажлын хүрээнд сумын Засаг даргын тамгын газартай гэрээ байгуулж нийт 3,000 тн эрчим хүчний угаасан нүүрсийг гурван жилийн турш нийлүүлэхээр боллоо. Сумын эрчим хүч, нэгдсэн халаалтад холбогдоогүй байгууллагууд, зорилтот бүлгийн айл өрхүүдэд тайлант онд 1,791 тн нүүрс үнэ төлбөргүй олгожээ.

УС ХАНГАМЖ

Бид ус хангамжийн системийнхээ хүрээнд уурхайн болон үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хангахаас гадна Цогтцэций сумыг ундны цэвэршүүлсэн усаар хангадаг. Тодруулбал, говийн хатуулаг ихтэй, шууд унданд хэрэглэхэд тохиромжгүй усыг өөрсдийн зардлаар бүрэн цэвэршүүлж, ундны усны стандартад нийцүүлэн нийлүүлдэг. Дунджаар жилд 120,000 м3 цэвэршүүлсэн усыг сумын иргэдэд улсын суурь үнээр нийлүүлж байна. Түүнчлэн Цогтцэций сумын төв, Ажилчдын хотхон, “Цэций” хорооллыг ариутгах татуургын нэгдсэн системд холбосон бөгөөд сумын төвд орчин үеийн, европ стандартын, хоногт 1,200 тн бохир ус хүлээж авч цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ажиллаж байна.

2021 онд Цогтцэций сумын иргэдийн унд ахуйн хэрэгцээнд 112.7 мянган м3 цэвэршүүлсэн ундны усыг төвлөрсөн шугам сүлжээ болон зөөврөөр, иргэд оторчдын малын усалгаанд 1,019м3, сумын иргэдийн хүнсний ногооны талбайн усалгаанд 23.3 мянган м3 усыг хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүйгээр, аж ахуйн нэгж, байгууллагуудад 30.6 мянган м3 усыг тус тус түгээсэн байна. Мөн онд сумын цэвэрлэх байгууламж нь 150 мянган м3 ахуйн бохир усыг төвлөрсөн шугам сүлжээ болон зөөврөөр хүлээн авч цэвэрлэжээ.

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг мөрдлөг болгож, хүний эрхийг дээдлэх, оролцогч, сонирхогч талуудын идэвхтэй оролцоог хангах, шударга, нээлттэй, ил тод байх зарчмуудыг баримтлан ажиллахыг эрмэлздэг.

Тайлант онд Ковид-19 цар тахлын нөлөөллийн улмаас улс орон даяар амаргүй нөхцөл байдал үүсч, компанийн үйл ажиллагаанд тааварлашгүй сорилт, бэрхшээлүүд олноор тулгарсан хүндхэн үе байсан. Гэсэн хэдий ч нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн засаг захиргаа, малчид, ард иргэд, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг оролцогч талуудтай хамтран орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, уламжлалт ажлуудыг аль болох хэвийн хэмжээнд үргэлжлүүлж, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг ханган ажиллалаа.

Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд компанийн орон нутагт оруулсан бүхий л хөрөнгө оруулалт нь тус бүс н-утгийн тогтвортой хөгжлийг дэмжих, цаашлаад орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд болон компанид үр өгөөжөө өгөх зорилго агуулагдаж байдаг. Компаниас нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй нийт төсөл, хөтөлбөрүүдэд шууд байдлаар 10,000 орчим хүн хамрагдаж байна.

Орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөр

Уурхайн нөлөөллийн бүсийн малчид, иргэдийн эрхийг хүндэтгэн тэдний өөрсдийн сонгосон жижиг, дунд бизнесийг дэмжиж, хамтран хөгжүүлэх зорилгоор “Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр”-ийг 2012 оноос хойш тууштай хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн хүрээнд иргэдэд жижиг, дунд бизнес эрхлэхэд нь 10 хүртэлх сая төгрөгийн зээлийг хүүгүй олгож, санхүүжилт ба эрсдлийг компаниас 100% хариуцан ажилладаг. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд Хас банк ба орон нутгийн “Амжилтын томьёо” бизнесийн зөвлөх ТББ-тай хамтран ажиллаж байна. Тус хөтөлбөрийн зээлийн санд зориулан 2017-2021 онд 250 сая төгрөгийг орон нутгийн Хас банкинд байршуулсан бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд давхардсан тоогоор 70 гаруй иргэнд 450 орчим сая төгрөгийн хүүгүй зээлийг гурав хүртэл жилийн хугацаатай олгосон байна.

Тайлант онд хөтөлбөрийнхөө цар хүрээг өргөжүүлж Цогтцэций сумаас гадна Цогт-Овоо, Ханхонгор сумын иргэдэд танилцуулга хийж, улмаар 15 иргэнийг төсөл боловсруулах сургалт болон судалгаанд хамрууллаа.

2021 оны 12-р сарын байдлаар нийт 15 иргэн идэвхтэй зээлдэгчээр бүртгэгдэж, зээлийн эргэн төлөлт хэвийн явагдаж байна. Төслийн үр дүнгээс харахад зээлийн хөтөлбөр нь орон нутгийн жижиг бизнесүүдэд бодит дэмжлэг болж, үр дүнтэй хэрэгжиж байна.

“Ойн зурвас” төсөл

Цөлжилт, хөрсний доройтлын эсрэг Цогтцэций суманд “Ойн зурвас” салхины хаалт байгуулах төсөл 2011 оноос амжилттай хэрэгжиж байна. Анх таван га талбайд 300 мод, бут суулгаж эхэлсэн бол өнөөдөр жилээс жилд нэмж мод тарьж, системтэй ургуулсаар нийт 23 га талбайд нийт 15,000 орчим мод бүхий говийн баян бүрд болон өргөжжээ.

“Ойн зурвас”-ын нийт найман га талбайг сумын иргэд болон шилжин суурьшсан ажиллагсдын гэр бүлийн гишүүдийн газар тариалан эрхлэх идэвхи санаачилгыг дэмжих, газар тариалан эрхлэх туршлага, ур чадварыг нэмэгдүүлэх, эрүүл төмс, хүнсний ногоогоор өрхийн хэрэгцээгээ хангах цаашлаад өрхийн бизнесийг нь дэмжих зорилгоор ашиглуулж байна. 2021 оны хувьд дөрвөн га талбайд нийт 70 өрх, хоёр аж ахуй нэгж 20 гаруй төрлийн төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал тариалж, 95 орчим тн ургац хураан авсан байна. Түүнчлэн өөрсдийн санаачилгаараа нэгдсэн “Ургац” бүлгийн ногоочид ногооны борлуулалт, техник тоног төхөөрөмжийн хүрэлцээг сайжруулах, зоорьтой болох гэх мэт асуудлаа хамтын хүчээр шийдвэрлэх зорилго тавин хамтран ажиллаж байгаа бөгөөд цаашид мод үржүүлгийн чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөтэй байна.

“Сайн хөрш” хөтөлбөр

“Сайн хөрш” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн оролцогч талуудтай тогтмол хамтран ажилласаар ирсэн. Тайлант онд иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй сайн хөршийн харилцааг эрхэмлэж, сумдыг эрчим хүний нүүрсээр хангах, малчин өрхүүдэд өвс тэжээлийн тусламж үзүүлэх, сар шинээр өндөр настнуудад гарын бэлэг гардуулах зэрэг ажлуудыг уламжлалын дагуу зохион байгуулж, орон нутгийн дэд бүтэц, тогтвортой хөгжлийг дэмжих ажлуудаа тууштай үргэлжлүүлэн ажиллалаа.

Өвс, тэжээлийн тусламж

Сүүлийн арав гаруй жилийн турш малчдад өвөл, хаврын хүнд хахир үеийг хохирол багатай даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор өвс, тэжээлийн тусламж үзүүлсээр ирсэн. 2021 онд 5,000 боодол өвс, 45 тн тэжээл, 1,125 ширхэг ашигт долооцыг татан авч Цогтцэций сумын 400 гаруй малчин өрх, Ханхонгор сумын Хондот багийн 30 гаруй өрхүүдэд өвс тэжээл, долооц тараасан. Үүнээс гадна Цогт-Овоо сумын Бор тээг багт ашигт долооц болон Ханхонгор сумдын фондод өвс, долооцны тусламжаа үзүүлэв. Мөн зэрлэг амьтдад зориулж байгаль орчны дүйцүүлэн хамгаалах ажилд өвс хандивласаар ирсэн.

Бэлчээрийн усан хангамж

Орон нутгийн малчдын хэрэгцээнд үндэслэн бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлэх зорилгоор 2012 оноос хойш жил бүр зун, намрын улиралд ус хангамжийн системийн гол шугамаас мал усалгааны зориулалтаар усны гаргалгаа цорго нээж өгсөөр ирсэн. Тайлант онд Цагаан-Овоо багийн малчид болон отрын малчдын хүсэлтээр Ус хангамжийн гүний 6, 10-р худгуудын дэргэд мал усалгааны зориулалттай худгийн хоёр гаргалгааг малчдад нээж өглөө. Ингэснээр нийт 10 орчим өрхийн 8,000 гаруй малын усалгааны хэрэгцээ хангагдаж, малчдын хөдөлмөрийг хялбарчилж байна.

ОРОН НУТГИЙН ХАНДИВ, ТУСЛАМЖ

Орон нутаг, оролцогч талуудын сайн хөршийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэмжлэг тусламжаа үзүүлэх зорилгоор зайлшгүй шаардлагатай үед мөнгөн болон эд материалын хандив, тусламжийг компанийн нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд үзүүлсээр ирсэн. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр сум, орон нутгийн төрийн байгууллагуудад холбогдох хандив тусламжийг үзүүллээ.

Тухайлбал, аймаг болон Цогтцэций сумын Онцгой комисст 15,000 ширхэг Ковидын түргэвчилсэн тест болон сумын эмнэлгүүдэд нийт 20 ширхэг эмнэлгийн зориулалттай олон үйлдэлтэй ор, хэрэгслийн хамт хандивлав. Түүнчлэн тус суманд хэрэгжиж байгаа “Модтой хашаа” төслийг дэмжиж 80 өрхөд таван төрлийн 480 гаруй суулгац хандивласан бол орон нутгийн ТББ-уудын хүчин чадавхийг дэмжих, үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр уурхайчин залууст зориулсан эрүүл мэнд, спортын арга хэмжээг ивээн тэтгэж ажиллалаа.



АМЖИЛТЫН ТҮҮХ

“Zoya’s Coffee shop” ын эзэн Б.Зоя анх 2018 онд гэр бүлийн хамт Эрдэнэт хотоос Цогтцэций суманд шилжиж ирж “Уурхайчин хороолол”-д суурьшсан. 2019 онд “Цэций” хорооллын хамгийн анхны кофе шоп-т ажилд орсон бөгөөд жил гаруйн дараа тус газрыг ажиллуулдаг хүн нийслэл рүү шилжих болсноор өөрийн бизнес болгон үргэлжлүүлэн ажиллуулах боломж гарчээ.

Түүнд бизнесээ эхлүүлэх гарааны хөрөнгө шаардлагатай болсон тул Энержи Ресурс компанийн хэрэгжүүлдэг “Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр”-т хандан 10 сая төгрөгийн зээл авснаар хувиараа бизнес эрхлэгч болсон түүхтэй.

“Zoya’s Coffee shop” нь “Цэций” хорооллын 6-р байранд үйл ажиллагаа явуулж, улмаар байнгын үйлчлүүлэгчидтэй болж бизнес нь өдрөөс өдөрт өргөжиж байна. Түүнчлэн гэрэээрээ түргэн хоол, бялуу хийж борлуулдаг 3 эмэгтэйдээс бүтээгдэхүүнийг нь гэрээгээр худалдан авч, тэдэнд орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байна.

V. АЖИЛЛАГСАД



₮68
(2021) **ТЭРБУМ**

ЦАЛИН,
УРАМШУУЛАЛ

156
(2021)

ШИНЭЭР БИЙ
БОЛГОСОН АЖЛЫН БАЙР

4%
(2021)

ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ
АЖИЛЛАГСАД

ҮНЭТ ЗҮЙЛ

Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал зүйл гэж бид үздэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинд нэн тэргүүнд анхаарна.
- Энержи Ресурс ХХК нь ур чадвар, ажлын үр дүнг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн адил тэгш боломжоор хангаж хариуцлагатай ажил олгогч байна.

БОДЛОГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Энержи Ресурс компани нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай 60 гаруй хууль журмыг мөрдөн ажиллахаас гадна Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенц болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, хамтын гэрээ хэлэлцээрийг чанд дагаж биелүүлдэг.

Эдгээр хууль тогтоомж, дүрэм журмын дагуу ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон, ажлын байрны аливаа дарамтнаас ангид нөхцлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн даатгалд даатгуулах зэрэг үндсэн заалтуудыг чандлан мөрддөг.


Бид Ухаа худаг төслийн аливаа үйл ажиллагаа, байгууламжид насанд хүрээгүй хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх эсвэл хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгт ашиглахыг тэвчихгүй. Тус компани нь 2016 онд батлагдсан Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийг чанд мөрдөхөөс гадна 1990, 2002 онд соёрхон баталсан Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай конвенц, 2002 онд соёрхон баталсан Насны доод хэмжээг тогтоох тухай конвенц зэрэг холбогдох бусад баримт бичиг, хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажилладаг.

Компанийн зүгээс ажлын байрыг нээлттэй, ил тод, шударгаар зарлаж хөдөлмөрийн зах зээл дээрээс хүний нөөцийн бүрдүүлэлт үүсгэн ажилладаг. 2021 оны 12-р сарын эцсийн байдлаар тус компани нийт 1,880 үндсэн ажиллагсадтай ба түүний 40%-ийг орон нутгийн иргэд, тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Баян-Овоо, Ханхонгор сумын иргэд зонхилон бүрдүүлж байна. Түүнчлэн Ухаа худаг цогцолборын хүрээнд шууд ба шууд бусаар нийт 2,500 гаруй хүнийг ажлын байраар хангадаг.

2021 онд хөл хорионы хүндрэлтэй нөхцөл байдал тулгарсан хэдий ч компанийн зүгээс нийгмийн хариуцлагаа өндрөөр ухамсарлан, ажиллагсдынхаа ажлын байр, цалин урамшууллыг бүрэн хадгалаад зогсохгүй 156 ажлын байр шинээр бий болгож, зайнаас ажиллах уян хатан бодлого нэвтрүүлэн ажилласан.

Тухайлбал, 6-аас доош насны хүүхэдтэй эмэгтэй ажиллагсдыг долоон хоногийн ажлын дөрвөн өдөр оффисоос, нэг өдөр гэрээс ажиллуулах, оффисын нийт ажиллагсдын ажлын цагийг өглөө 08-10, орой 17-19 буюу уян хатан ирүүлэх, вакцинд хамрагдах боломжгүй 12-оос доош насны хүүхэдтэй ажиллагсдыг зайнаас ажиллах боломжоор хангах гэх мэт шинэлэг зохицуулалтуудыг нэвтрүүлэн ажиллаж байна.

Ажиллагсдын тоо



АЖЛЫН БАЙР, ТЭГШ БОЛОМЖ

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэгчийн хувьд ажиллагсдынхаа эрхийг дээдэлж, ижил тэгш боломжоор хангахыг зорьдог.

Компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтны нас, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл баримтлал, оршин суугаа орон нутаг, харъяалал зэргээс үл хамаарсан цалин, хөлс олгож, тэгш хөгжих боломжийг хангадаг бөгөөд цалингийн зөрүү нь зөвхөн тухайн ажилтны боловсрол, ур чадварын түвшин, туршлага болон зэрэг, дэв зэргээс хамаардаг.

АЖЛЫН БАЙРНЫ ТЭГШ БОЛОМЖ	2019	2020	2021
30 хүртэлх насны ажиллагсад	32%	30%	26%
30-50 хүртэлх насны ажиллагсад	62%	64%	68%
50-с дээш насны ажиллагсад	6%	6%	6%
Эмэгтэй ажиллагсад	13%	13%	14%
Удирдах түвшний эмэгтэй ажиллагсад	14%	32%	33%
ТУЗ дэхь эмэгтэйчүүд	12%	12%	12%
Хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсад	4%	4%	4%

2021 онд нийт ажиллагсдын ойролцоогоор 14%-ийг эмэгтэй ажиллагсад бүрдүүлсэн бөгөөд удирдах түвшний ажилтнуудын 33% нь эмэгтэйчүүд байгаа нь дотоодын төдийгүй олон улс дахь уул уурхайн салбарын дунджаас дээгүүр үзүүлэлт юм.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах ажлын хүрээнд хүнд машин механизмын операторын мэргэжил олгох сургалтанд хамруулдаг. Орон нутагт ээлжээр ажилладаг эмэгтэй ажиллагсдын байр, орон сууцны нөхцлийг сайжруулах ажлууд байнга хийгдэж ирснээс гадна тайлант оноос эхлэн 0-6 настай хүүхэдтэй эмэгтэй ажиллагсдыг ажлын таван өдрийн нэг өдөрт гэрээс ажиллах боломжийг бүрдүүлэх гэх мэт шинэ зохицуулалтуудыг Улаанбаатар оффист нэвтрүүлэн ажилласан. Ажиллагсдыг насны ангиллаар нь авч үзвэл нийт ажиллагсдын дийлэнхи буюу 68%-ийг 30-50 хүртэлх насныхан, 26%-ийг 30 хүртэлх насныхан бүрдүүлж байна.


2021 онд нийт 74 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж тогтмол орлоготой байхад нь дэмжлэг үзүүлэн ажиллажээ. Ингэснээр Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нийт ажиллагсдын дөрөв ба түүнээс дээш хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохицуулалтыг бүрэн ханган ажиллаж байна.

ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Бид 2021 онд шинээр 156 хүнийг ажлын байраар хангаснаар ажиллагсдын шилжилт хөдөлгөөний сүүлийн нэг жилийн үзүүлэлт 12 орчим хувьтай байна.

Хэдийгээр хөдөө орон нутагт чадварлаг боловсон хүчний нөөц туйлын дутмаг байдаг ч ажиллагсдын шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой байдаг нь компанийн зүгээс ажиллагсдынхаа нийгмийн асуудалд анхаарч, хөнгөлөлт, хангамжийн бодлогоо хэвээр хадгалан, гэр бүлээр нь орон нутагт шилжүүлэн суурьшуулах хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүн юм. Тайлант хугацаанд орон сууцны "Цэций" хороололд 66 ажилтныг, "Уурхайчин" хороололд 22 ажилтныг гэр бүлийн хамт тус тус суурьшуулсан. Тогтвортой ажиллах гэрээний үүргээ биелүүлсэн нийт 88 ажилтанд орон сууц болон хашаа газрын өмчлөлийг үнэ төлбөргүй шилжүүлж өгсөн байна. Компанийн нийт ажилтнуудын 47% нь тогтвор суурьшилтайгаар тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа нь компанийн зүгээс ажилтнуудаа ижил, тэгш боломжоор хангаж ирсний үр дүн юм.

Шинээр бий болгосон
ажлын байр



СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Компани байгуулагдсан цагаас эхлэн мэргэжилгүй иргэдийг уул уурхайн чиглэлээр мэргэшүүлж, ажлын байраар хангах, ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулсаар ирсэн.

Ур чадварын үнэлгээнээс ажиллагсдын ерөнхий болон мэргэжлийн ур чадварын сургалтуудын төрлийг тодорхойлдог. 2021 онд давхардсан тоогоор нийт 10,000 орчим ажиллагсдыг 54 төрлийн сургалтанд хамруулсан бөгөөд үүнээс 7,850 хүнийг ерөнхий ур чадварын 1,817 хүнийг нарийн мэргэжлийн сургалтанд тус тус хамруулжээ. Тодруулбал 75,000 хүн/цаг сургалт явагдсан бөгөөд нэг ажилтанд дунджаар 7.1 цагийн сургалт ногдож байна. Мөн тайлант хугацаанд Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан ажиллагсдад зориулсан сургалтын хэлбэр, аргачлалыг өөрчилж, цахим сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулж, зайн сургалтын арга зүй, сургалтын материалыг голчлон ашигласан.

Компанийн зүгээс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах ажлын хүрээнд хүнд машин механизмын операторын мэргэжил олгох сургалтанд хамруулдаг. 2021 онд 271 эмэгтэйг хүнд машин механизмын оператор бэлтгэх сургалтанд хамруулан, ажлын байраар хангалаа.

14%

(2021)

ЭМЭГТЭЙ
АЖИЛЛАГСАД

33%

(2021)

УДИРДАХ ТҮВШНИЙ
ЭМЭГТЭЙ
АЖИЛЛАГСАД



VI. БАЙГАЛЬ ОРЧИН



130

(2021-2021) МЯНГА

НИЙТ ТАРЬЖ
УРГУУЛСАН МОД

26.5%

(2021)

ХОГ ХАЯГДЛЫН
ДАХИН
БОЛОВСРУУЛАЛТ

95%

УСНЫ ДАХИН
АШИГЛАЛТ

Компанийн байгуулсан Ойн зурвас, Өмнөговь аймгийн Цогтцэций сум

ҮНЭТ ЗҮЙЛ

Бид байгаль орчны хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

- Энержи Ресурс ХХК-ийн уурхай, дагалдах инженерийн бүтцийг байгаль орчинд аль болохоор бага нөлөөлөл учруулахаар зохион байгуулна.
- Энержи Ресурс ХХК нь шаардлагатай бүх байгаль орчны стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна.

БОДЛОГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Энержи Ресурс компани нь Ухаа худаг төслийн бүхий л үе шатанд байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, байгаль орчныг хамгаалах багц хууль, стандартууд, Олон улсын стандартуудыг даган мөрдөж, үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг. Тодруулбал хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл эвдрэл, нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн бие даасан менежмент төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлж байна.

Бид үйл ажиллагаагаа Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Хэмжлийн нэгдмэл байдлын тухай, Ариун цэврийн тухай, Усны тухай, Ус, Рашаан ашигласны төлбөрийн тухай, Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай зэрэг Монгол Улсын 30 орчим хуулиуд болон бусад холбогдох 200 гаруй хууль тогтоомж, журам заавар, стандартын дагуу хэрэгжүүлэн ажилладаг.

Түүнчлэн Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (БОХАБЭА)-н бодлогын хүрээнд олон улсын ISO 14001:2004 "Байгаль орчны удирдлагын тогтолцоо" болон OHSAS 18001:2007 "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо" стандартын шаардлагатай нийцүүлсэн, нэгдсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү нэгдсэн удирдлагын тогтолцоо нь БОХАБЭА-н бодлого, зорилго, зорилт, шаардлага болон тэдгээрт хүрэх арга замыг тодорхойлсон цогц систем тул

компаниас хэрэгжүүлж буй бүхий л төсөл, үйл ажиллагаанд хүрч мөрдөгддөг. Бид нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц зэрэг гол бүтээн байгуулалтууддаа говийн нөхцөлд тохирсон байгаль орчинд ээлтэй, ус хамгийн бага ашиглах технологийг ашигладаг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулан, төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэн ажилладаг. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамд заасны төлөвлөгөөний биелэлт нь 90%-иас дээш байх шаардлагатай байдаг.

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны газар, газрын хэвлий түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, Цогтцэций сумын Уул уурхай-ус хариуцсан байгаль хамгаалагч, Орон нутаг хариуцсан байгаль хамгаалагч, сумын иргэний төлөөллийн бүрэлдэхүүнтэй комисс компанийн 2021 оны төлөвлөгөөний биелэлтийг 97.4%-тай гэж дүгнэсэн.

Байгаль орчны багаас говь нутагт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 2009 оноос хойш нийт 130,000 гаруй мод тарьж ургуулснаас 2021 онд 8,000 орчим тарьцыг үржүүлэн бойжуулж 5,500 гаруй мод сөөгний суулгац тарьсан бөгөөд нийт модны амьдралтын хувь 85%-иас дээш байна.

НӨХӨН СЭРГЭЭЛТ

Газрыг зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээж улмаар ирээдүйд бэлчээр болон бусад байдлаар ашиглах боломжтой болгож үлдээх нь хариуцлагатай уул уурхайн нэн чухал хэсэг юм.

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд барих зорилго тавин ажилладаг бөгөөд жил бүр нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. 2021 онд нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд уурхайн хаягдлын овоолгын 32 га талбайг налуулж, хэлбэршүүлэн, техникийн нөхөн сэргээлт хийсэн ба 8 га талбайг шимт хөрсөөр хучих, 3 га талбайг ургамалжуулах ажлыг гүйцэтгэн, биологийн нөхөн сэргээлт хийсэн.



ХАЯГДЛЫН ОВООЛГЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨСӨЛ

Ухаа худаг уурхайн техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан гадаад овоолгын техникийн ба биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн, зохих аргачлалын дагуу хийх ажлыг 2009 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тайлант онд уурхайн хаягдлын овоолгын налуулж, хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих биологийн нөхөн сэргээлтийн эхний үе шатны ажлыг 10 га талбайд, шимт хөрсөөр хучсан хэсэгт ургамалжуулалт хийж, биологийн нөхөн сэргээлт гүйцэтгэх ажлыг 2021 онд 1.8 га талбайд эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэв.

Хаягдлын овоолгыг сэргээн засварлах нь Монголын говьд анх удаа хийгдэж байгаа ажил бөгөөд цаашид газрын өнгөжилтийн чанарыг сайжруулах шаардлагатай байгаа нь энэ ажлыг гүйцэтгэх явцад харагдсан. Бид нөхөн сэргээлт хийхдээ талбайг гадаргын урсацаас хамгаалах зорилгоор 1,276 м урт чулуун доторлогоотой шуудуу татсан. Түүнчлэн ургамлын бүсэд усалгааны систем, усны сав суулгаж, тогтмол усалгааг хуваарийн дагуу хийж гүйцэтгэж байна. Ургамлын хувьд хөрсний шим тэжээлийг нэмэгдүүлэх, сайжруулах зорилгоор олон наст болон нутгийн ургамлуудыг сонгосон.

УС ХАНГАМЖИЙН ЦОГЦ МЕНЕЖМЕНТ

Ухаа худаг уурхайн цогцолбор нь үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилласнаар уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангадаг.

Монгол Улсын Усны тухай хууль, MNS 4943:2015 үндэсний стандартыг мөрдөхөөс гадна Олон Улсын Санхүүгийн Корпорацийн санаачилга "Өмнийн говийн усны менежементийн Сайн дурын кодекс"-ын гишүүнээр элсэж, гарын үсэг зуран нэгдсэн бөгөөд усны хэмнэлт, дахин ашиглалтын мэдээллээ сайн дураар тайлагнадаг.

Говь нутгийн ус нь эрдэсжилт, хатуулаг ихтэй учраас ундны усанд тогтмол хэрэглэх нь тохиромжгүй байдаг. Иймд Энержи Ресурс компани ундны усыг цэнгэгжүүлж, Цогтцэций сумын хүн ам болон уурхайн ажиллагсдын хотхоныг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэржүүлсэн усаар хангасаар ирсэн. Усны хэрэглээ, олборлосон ус, хэрэглэсэн ус, цэвэршүүлсэн бохир усны хэмжээг хянах, хянахын тулд бид бодит цагийн мэдээлэл цуглуулах нэгдсэн телеметрийн хяналтын системийг ашигладаг.

Бид уурхайн талбайд гүний болон дахин боловсруулсан усыг хослуулан ашигладаг.

- 2021 онд газрын доорхи усыг татан авах нийт хэмжээ ойролцоогоор 42%-иар буурсан.
- Ус уурших, шүүрэхээс бүрэн хамгаалагдсан, 56 000 куб метр ус агуулах хоёр ширхэг усан сан нь усны ууршилт, нэвчилтийг бүрэн хязгаарласан дэвшилтэт технологийн шийдэлтэй.
- Ухаа худагийн цахилгаан станц л гэхэд ердийн цахилгаан станцуудаас 4-5 дахин бага ус ашиглах технологитой.
- 60 мл орчим гадаргын урсацын усыг зориулалтын цөөрөмд цуглуулж, уурхайн талбайд төрөл бүрийн зориулалтаар ашигласан.
- 150 гаруй мл ахуйн бохир усыг цэвэршүүлж, мод услах, уурхайн тоос дарах зэрэгт ашигласан.
- Малчдын худгийн усны түвшин, уурхайн орчмын цооног болон ус олборлох талбайн хэмжээг сар бүр хянаж, хэмжилт хийсэн.

Түүнчлэн Нүүрс баяжуулах үйлдвэрийнхээ дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийг ажиллуулж, хаягдал лагаас усыг шавхаж авах замаар усны дахин ашиглалтыг 95%-д хүргээд байгаа билээ.

Мөн ахуйн зориулалтын усны хэрэглээг бууруулах ажлын хүрээнд Дэлхийн усны өдрийг тохиолдуулан ерөнхий боловсролын сургуулийн 130 сурагчдад "Усны хэрэглээ" сэдвээр сургалт зохион байгууллаа.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ


Ухаа худаг төслийн үйл ажиллагааны явцад үүсэх үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээг тодорхойлох, хаягдлыг дахин боловсруулах, ангилах, хог үүсэлтийн хэмжээг хянаж бууруулах зорилгоор хог хаягдлын нэгдсэн бүртгэлийг үүсгэж, сар бүр анализ хийдэг.

Мөн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ "3R+R" системийг ашигладаг. Тухайлбал, ангилан ялгасан хог хаягдлыг дахин ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дахиврын цехийг дэргэдээ ажиллуулж, олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

2021 онд уурхайн талбайн үйл ажиллагаанаас үүдэлтэй хатуу хог хаягдлын нийт хэмжээ 9,448.5 м³ байсан бөгөөд хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээ 36 хувиар нэмэгдсэн. Түүнчлэн Ковид-19 цар тахлын улмаас уурхайд үүссэн хог хаягдлыг зохих журмын дагуу шаардлагад нийцүүлэн ангилан ялгаж цуглуулах, устгах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Төслийн үйл ажиллагааны явцад бий болсон хог хаягдлыг эрх бүхий "Паблик сервис" ХХК-тай гэрээ байгуулан, тээвэрлүүлж, устгуулдаг.

Мөн төслийн нийт талбайн хэмжээнд их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, хоггүй цэвэр орчныг бүрдүүлэн ажилладаг бөгөөд тайлант хугацаанд зам талбайд тархсан хог хаягдлын цэвэрлэгээг нийт 17 удаа зохион байгуулж, нийт 7.6 м³ хог хаягдлыг цуглуулж төвлөрсөн цэгт

Хог хаягдлын дахин боловсруулалт






ГОВЬ ГУРВАН САЙХАН ДАХЬ ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт Монгол орны хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон нийт 8,000 га талбайг нөхөн сэргээх “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх зорилт тусгагдсан. Энэхүү зорилгод манай компани нэгдэж, 2021 онд гар аргаар алт олборлолтын улмаас эвдрэлтэнд орсон, Өмнөговь аймгийн Баяндалай сумын Баян цагааны нуруу, Цогтцэций сумын Наймдайн хөндийн нийт долоон га талбайд техникийн нөхөн сэргээлтийг холбогдох стандартын дагуу амжилттай хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартын дагуу техникийн нөхөн сэргээлт хийснээр хүн, мал амьтан унаж бэртэх, осол эрсдэлийг бууруулж байна.

Нийт хог хаягдлын устгал (2021)



хүргүүлсэн бол сум орон нутгаас зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээнд үндсэн болон гэрээт компанийн 56 хүн оролцож нийт 36м3 хог хаягдлыг түүж цуглуулан цэвэрлэсэн.

Хог хаягдлын төрлүүдийг тогтоон, ангилан ялгалт хийж, дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх, нийлүүлэгч байгууллагад буцаах байдлаар ажиллаж байна. Органик хог хаягдал ба хоолны хаягдал, цэвэрлэх байгууламжийн лагийг ашиглан компост бордоо хийх туршилт судалгааны ажил хэрэгжүүлсэн. Ажлын бүх байранд хог хаягдал ангилан ялгах зориулалтын савыг байрлуулсан ба ажилчдад хог хаягдлын менежментийн зохистой дадал хэвшлийн талаарх

сургалт мэдээллийг тогтмол олгодог.

Төслийн үйл ажиллагаанаас үүсч байгаа дахин ашиглагдах буюу дахин боловсруулагдах боломжтой хог хаягдлыг бүтээгдэхүүн болгож, байгаль орчинд хаягдах хогны хэмжээг бууруулах үүднээс дахиврын цехтэй хамтран ажилладаг. Уг цехэд дахин ашиглагдах/боловсруулагдах хог хаягдал буюу хоёрдогч түүхий эдүүдийг ашиглан блок, хогийн сав, модон вандан сандал болон гүйдэг хаалга, төмөр хашаа зэрэг бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэж байна. Тухайлбал, тайлант онд 2,040 хаягдал тосны шүүлтүүрийг ашиглан уурхайн талбайд 510 ширхэг замын шон хийж, 10 орчим сая төгрөг хэмнэсэн.

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

Бид аюултай хог хаягдлын менежментийн бодлогынхоо дагуу бүх төрлийн аюултай хог хаягдлын шинж чанар, эрсдэлийг тодорхойлж, үнэлэхийг шаарддаг.

Энэ дагуу аюултай материалыг тээвэрлэх, хадгалах, ашиглах, шилжүүлэх, устгахтай холбоотой урьдчилан сэргийлэх хяналтын арга хэмжээг хэрэгжүүлдэг. Тайлант хугацаанд дахин боловсруулсан аюултай хог хаягдлын эзлэх хувь 16 орчим байсан нь өмнөх оны үзүүлэлттэй ижил түвшинд байна.

Аюултай хог хаягдлыг төрлөөс нь хамааруулан дахин ашиглах эсвэл зохих ёсоор устгах зорилгоор нийлүүлэгчид буцааж хүргэдэг. Тухайлбал, тайлант онд нийт 522 хүнд машин механизмын ашигласан аккумуляторыг нийлүүлэгчид, 364 аккумуляторыг хог боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгжүүдэд хүргүүлжээ. Ашигласан тосыг цуглуулж, дахин боловсруулах нь газрын тос, хөрс, гүний усыг бохирдуулахаас урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй. 2021 онд 279 тонн ашигласан тосыг зориулалтын саванд цуглуулан түлш болон бусад төрлийн түүхий эд үйлдвэрлэдэг дахин боловсруулах үйлдвэрт илгээсэн байна. Мөн хаягдал тосны шүүлтүүр, принтерийн хор, аккумулятор зэргийг зохих журмын дагуу хадгалж, зохицуулж, дахин ашигладаг.

2021 онд нийт 1,540 м3 орчим аюултай хог хаягдлыг шатааж, 458 м3 хог хаягдлыг булшилж, 389 м3 аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, 116 м3 хог хаягдлыг зохих журам, мөрдөж буй стандартын дагуу хадгалахад тус тус илгээжээ. Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор үүссэн аюултай хог хаягдал ялангуяа эмнэлгийн ба нэг удаагийн хог хаягдлуудыг холбогдох шаардлагын дагуу тусгайлан устгалд оруулсан.

АГААРЫН ЧАНАР

Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт болон агаар бохирдуулагч хийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр тодорхой ажлууд хийж хэрэгжүүлдэг. Ухаа худаг уурхайн хүрээнд дуу, шуугианы эх үүсвэр, түвшнийг тогтмол үнэлж хянадаг. Мөн тоосжилтын нөлөөллийг хянах зорилгоор тоосны хэмжилтийг Ухаа худаг уурхай, Цогтцэций сум, Цагаан хадан дахь тодорхой цэгүүдэд тогтмол хийсээр ирсэн. Тайлант хугацаанд дээрх цэгүүдэд MNS 4585:2016 стандартын дагуу PM2.5-ын түвшний хэмжилтийг 100 гаруй удаа хийжээ. Жилийн туршид PM2.5-ын дундаж түвшин ихэнх хэмжилтийн цэгүүдэд агаарын чанарын улсын стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс (0.05 мг/м3) доогуур байна. Ухаа худаг уурхай болон ойр орчмын 10 хяналтын цэгт дуу чимээний түвшинг үргэлжлүүлэн хэмжихэд үр дүн нь Монгол Улсын стандартад бүрэн нийцсэн байна.

Тайлант хугацаанд компанийн зүгээс нүүрс олборлох явцын тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн технологийн замын материалыг улаан шавран материалаар засах, технологийн замыг тогтмол услах, тээвэрлэлтийн хурдыг багасгах, цахилгаан станцын нарийн үнс баригч филтерийг горимын дагуу ажиллуулах, нүүрс баяжуулах үйлдвэрийн тэжээлийн туузан дамжуурга дээр суурилуулсан өндөр технологийн тоос цуглуулагч филтерийн засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийж тогтмол ажиллагааг хангах зэрэг ажлыг гүйцэтгэн ажиллалаа. Нүүрс баяжуулах үйлдвэрийн тэжээлийн туузан дамжуурга дээр суурилуулсан тоос цуглуулагчийг ажлын байранд ажиллуулах үед тоосны агууламж 50 орчим хувиар буурсан болохыг тогтоосон.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

Уур амьсгалын өөрчлөлт, нүүрсхүчлийн хийн ялгарлын эсрэг дэлхий нийтийн хүчин чармайлт эрчимжиж байгаа энэ үед уул уурхайн компаниуд эдгээр ялгаруулалтыг бууруулах төрөл бүрийн арга, технологи дээр илүү шаргуу ажиллаж байна.

Бид 2017 оноос эхлэн компанийн үйл ажиллагааны явцад үүсч байгаа хүлэмжийн хийн ялгарлыг хянах зорилгоор ялгарч буй хүлэмжийн хийн тооцооллыг хийж тайлагнаж эхэлсэн. Уг ажлын хүрээнд хөдөлгөөнт тоног төхөөрөмж болон цахилгаан станцаас ялгарч буй хүлэмжийн хийн агуулгыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалаар тооцоолж байна.

2021 онд хүлэмжийн хийн нийт ялгарал өмнөх оныхтой харьцуулахад 32% багассан ба энэ нь нүүрс олборлолт болон боловсруулалтын хэмжээ бага байсантай холбоотой байна. Мөн хүлэмжийн хийн ялгарлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг тогтмол төлөвлөн хэрэгжүүлдэг бөгөөд цахилгаан станцаас ялгарах хүлэмжийн хийг бууруулах үүднээс утаа шүүгчийн бүрэн ажиллагааг хангах, горимын тохиргоог хийх, жил бүр ногоон байгууламжийг өргөтгөж мод тарих гэх мэт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ	2020	2021
GHG/CO2-e/t/	390,162	266,647
Scope 1	257,751	179,496
Scope 2	91,758	80,613
Scope 3	40,653	6,538
Үйлдвэрлэл	4,719,662	2,449,000
Эрчим	0.083 t CO2	0.108 t CO2

Орчны агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл зэргийн агаарт ялгарах хэмжээг бид агаарын чанарын үндэсний стандарт MNS 4585:2016 стандартын дагуу Ухаа худаг дахь эрх бүхий лабораторитоо тогтмол хэмждэг. Тайлант оны хувьд агаар бохирдуулагч хийн ялгаруулалтын хэмжээ өмнөх оноос буурч, зөвшөөрөгдөх хэмжээнээс доогуур байна.

ЭРЧИМ ХҮЧ, УСНЫ ХЭМНЭЛТ

Байгалийн нөөцийг үр ашигтай, хариуцлагатай ашиглах нь байгаль орчны тогтвортой байдалд чухал ач холбогдолтой гэдгийг бид хүлээн зөвшөөрч, эрчим хүч, усны хэрэглээгээ багасгах чиглэлд анхаарч ажилладаг. Ус, эрчим хүч, түүхий эд зэрэг нөөцийг үр ашигтай, хариуцлагатай ашиглахдаа Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Усны тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулиудыг удирдлага болгон ажиллаж байна. Үүний дагуу компани


нь эрчим хүч, байгалийн нөөцийг үр ашигтай ашиглахад чиглэсэн Менежментийн нэгдсэн төлөвлөгөөний бодлогыг батлав.

Бид үйл ажиллагаандаа гүний болон дахин боловсруулсан усыг хослуулан ашигладаг бөгөөд ус хэмнэх технологиор дамжуулан усны оновчтой үр ашгийг хангахыг зорьдог. Усны хэрэглээ, олборлосон ус, хэрэглэсэн ус, цэвэршүүлсэн бохир усны хэмжээг хянах, хянахын тулд бид бодит цагийн мэдээлэл цуглуулах нэгдсэн телеметрийн хяналтын системийг ашигладаг.

Түүнчлэн компанийн дотоод эрчим хүчийг бууруулах төлөвлөгөөний дагуу 2021 онд хэд хэдэн шинэ санаачилга хийхээр төлөвлөж байсан ч ихэнх нь тахлын нөхцөл байдлын улмаас түр хойшлогдсон.

Ухаа худагийн цахилгаан станц нь эрчим хүчний хэмнэлтийг үе шаттайгаар сайжруулахад чиглэсэн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байдаг. Мөн бид талбайнхаа үйл ажиллагааны бүх түвшинд эрчим хүчний хэмнэлттэй холбоотой практик арга хэмжээ, техникийн зохицуулалтыг хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, усан хангамжийн систем, цахилгаан станцын гэрэлтүүлэгт эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлснээр 2021 онд 21094 кВт эрчим хүч хэмнэж, нүүрсхүчлийн хийг 16.7 тн орчим бууруулсан байна.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн дахин боловсруулсан усны хэрэглээ (л/ром.тн)



Мөн тайлант онд ус дахин боловсруулах технологийг үргэлжлүүлэн сайжруулж, туузан шүүлтүүрийн прессийн байгууламжийг ажиллуулснаар гүний ус татах хэмжээ улам буурч, нэг тн боловсруулсан нүүрс тутамд хэрэглэх түүхий усны хэмжээ өмнөх оноос 3.5%-иар буурсан.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр ажилласнаар нийт усны дахин ашиглалтын хувь хэмжээ 95% орчим хувьтай байдаг.

МОД ҮРЖҮҮЛЭГ

Байгаль орчны нөхөн сэргээлт, орчны тохижилтод зориулж 2009 оноос эхлэн бид Мод үржүүлэг, нөхөн сэргээлтийн тусгай талбай байгуулсан. Уг талбайд мод, сөөг үржүүлж бойжуулах, улмаар тэдгээрийг уурхай, сумын төв, кэмп, орон сууцны хороолол болон зам дагуу шилжүүлэн суулгалт хийн ажиллаж байна.

2021 оны хаврын улиралд талбайн хөрс боловсруулалтын ажлыг эхэлж, тоорой, жигд, сухай, хонхот харгана, шар хуайс, заг, улиас, голт бор зэрэг найман төрөл зүйлийн 8,061 ширхэг модыг үр болон мөчрөөр тарьж ургуулан арчилгаа, хамгаалалтыг хийж байна.

Түүнчлэн Ухаа худаг төслийн талбайн хатуу хучилттай авто замын дагуу байрлах талбай мөн Цэций хороолол, цэвэрлэх байгууламж, Цагаан хаданд тарьсан модтой талбайнуудыг хашаажуулж, усалгааны систем, ус нөөцлүүр суурилуулж нөхөн тарилт болон талбайг өргөтгөн мод тарилтын ажлыг аравдугаар сард зохион байгуулсан бөгөөд тарилтын ажилд 60 орчим хүн хамрагдсан. Тайлант онд уг ногоон байгууламжийн талбайнуудад нийт 5,500 ширхэг мод, сөөг нэмэлтээр тарилаа. Нийт мод, сөөгний амьдралтын хувь 85 хувиас дээш байна.

БИОЛОГИЙН ОЛОН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ХАМГААЛАЛ

Бид 2009 оноос хойш Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөт ажлын хүрээнд зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хийж ирсэн бөгөөд 2021 оны 2, 4-р саруудад Цогтцэций сумын баруун талд байрлах Хангинах, Номт, Майхан уул зэрэг таван байршилд нийт 80 боодол өвс, 10 хайрцаг долооц, гурван шуудай хужир байршуулсан.

Ийнхүү зэрлэг амьтдад нэмэгдлээр ус, өвс тэжээл тавьж байгаа нь тэдгээр амьтдыг өлдөх, хоол тэжээлийн хомсдолд орохоос урьдчилан сэргийлэх зорилготой. Мөн зэрлэг амьтдын ажиглалт хийх зорилгоор Хангинах ууланд автомат камер байрлуулсан. "Говь гурван сайханы байгалийн цогцолбор" газрын захиргаанд уулын туруутан амьтдад зориулж 100 боодол өвсийг, Ханбогд сумын Засаг даргын тамгын газарт мөн 30 боодол өвсийг тус тус хүлээлгэн өгсөн. Нүүрс ачиж буулгах талбайн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний хүрээнд биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тус ажлын хүрээнд Цагаан хадан дахь уст цэгийг засварлаж ойролцоогоор 500 тн усыг зөөвөрлөж дүүргэсэн бөгөөд засмал замын зүүн талд шинээр цэг үүсгэн усаар хангаж, ойролцоо газарт нь 20 боодол өвс байрлуулсан.

Шувуудын ажиглалт судалгааны хариу арга хэмжээ

Энержи Ресурс компани нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээнээс гадна жил бүр төслийн үйл ажиллагаа явагдаж буй Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханхонгор, Ханбогд, Баян-Овоо сумдын нутгуудад хөрс, ургамал ба амьтны аймгийн судалгааг хийж гүйцэтгэдэг. Төслийн талбайн ойр орчмын суурин болон нүүдлийн шувуудад хийсэн ажиглалт судалгаагаар шувууд өндөр хүчдлийн шон дээр сууж, цахилгаанд цохиулан олноор эрсдэх тохиолдол ихээр гарч байгааг тогтоосон.

Иймд ус хангамжийн системийн Наймант ба Наймдайн хөндийд байрлах гүний усны худгуудыг холбосон 10 кВ-ын 60 км шугамын 700 гаруй тулгууруудад шугамын утасны фаз тус бүрт хөндлөвчөөс хоёр тийш 80 см урттай тусгаарлагч бүрээс хийж гүйцэтгэлээ.

Уг ажлыг гүйцэтгэснээр шувууд агаарын шугамын хөндлөвч дээр шувуу суух болон нисэх үед далавчаар гүйдэл дамжуулагчид хүрч улмаар шувууны хорогдол гарах эрсдлийг өндөр хувиар бууруулж чадсан.

Иргэдийн оролцоот хяналт мониторинг

Орон нутгийн иргэдэд байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг танилцуулах, байгаль орчны хээрийн хэмжилтэнд иргэдийг оролцуулах, хэмжилтийн бодитой мэдээллийг иргэдэд өгөх зорилготой сургалт, танилцуулгын ажлыг тогтмол зохион байгуулж ирсэн.

2021 онд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан олон нийтийг хамарсан арга хэмжээ хамтын оролцоотой орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг зохион байгуулаагүй бөгөөд худаг ус ашиглагч өрхүүдэд тухай бүрт мэдээллийг өгч ажиллалаа.

VII. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ



0, НОЦТОЙ ОСОЛ ГЭМТЭЛ
ХУГАЦАА АЛДСАН ГЭМТЛИЙН ДАВТАМЖ
МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛАХ ӨВЧЛӨЛ

5.9 САЯ АЖИЛЛАСАН ХҮН/ЦАГ (2021)

БОДЛОГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Энержи Ресурс компани нь эрхэм зорилго, үнэт зүйлсийг баримтлан, ажилтанд ээлтэй, эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх, ажлаа аюул осолгүй гүйцэтгэх боломжийг ханган Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулдаг.

Бид бүхий л үйл ажиллагаандаа олон улсын Хөдөлмөрийн Эрүүл Мэнд, Аюулгүй байдал (ХЭМАБ)-н ISO 45001-2018 стандарт болон Монгол Улсын ХАБЭА-н тухай хуулийг чанд мөрдөн ажиллаж байна.

Түүнчлэн ХАБЭА-н бодлогыг тасралтгүй сайжруулах, ослыг бууруулах, аюул эрсдэлийн хяналтыг сайжруулах зорилгоор ХАБЭА-н бүх журам гурван жил тутам хянагдаж, тасралтгүй шинэчлэгдэн, сайжирч явдаг. Тайлант хугацаанд нийт 35 журам хянагдаж, зохих өөрчлөлт, шинэчлэлтүүдийг оруулан батлуулсан байна.

Монголын уул уурхайн компаниудаас анх удаа Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны OHSAS 18001:2007 стандартыг нэвтрүүлж, олон улсын стандартын шаардлагыг хангасан компани болсон. Компанийн хэмжээнд осол бууруулах болон аюулгүй ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж, 2021 оны байдлаар 5.9 сая хүн/цаг ажиллан, хөдөлмөрийн чадвар түр алдалт болон мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдолгүй ажиллаж байна.

Ажилтнууд манай компанийн амин чухал үнэт зүйл гэж бид үздэг тул ХАБЭА-н орчинг нэн тэргүүнд анхаардаг. Бидний зорилго бол мэргэжлээс шалтгаалах өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй сайжруулах явдал юм.

2021 онд Нийт гэмтлийн давтамж 38.4 хувиар, хугацаа алдсан гэмтлийн давтамж 45 хувиар тус тус буурч, компанийн хэмжээнд үүсэн байгуулагдсан цагаас хойш анх удаа хугацаа алдсан гэмтлийн давтамж 0 гарсан үзүүлэлттэй ажилласан байна.

Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан, нийт ажиллагсдаа эрүүл, аюулгүй орчинд ажиллуулахаас гадна, өөрийн үйл ажиллагааны хүрээнд оролцогч бүх талуудын аюулгүй байдлыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн хангахыг эрмэлздэг.

Ухаа худаг төслийн хүрээнд олон улсын "ISO 14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцоо" болон "OHSAS 18001:2008 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага удирдлагын тогтолцоо" стандартаас Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо "ISO 45001-2018" стандарт руу шилжиж, стандартуудын шаардлагын дагуу БОХЭМАБ-н удирдлагын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэн дахин баталгаажуулалтын аудитаар баталгаажуулан ажиллаж байна.

Мөн уурхайн үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон олон нийт, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагад нэн тэргүүний ач холбогдол өгч "Аюулгүй эхэлж, аюулгүй дуусгая" уриаг эрхэмлэн ажиллаж ирсэн.

Тайлант онд:

- Өмнөговь аймаг болон Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт шалгалтаар эрсдэл үүсэх магадлал "Бага" буюу 93-ээс дээш хувийн үнэлгээтэй тус тус шалгагдсан.
- 2021 онд хугацаа алдсан гэмтлийн давтамжийн үзүүлэлт 0.00 байсан нь үйл ажиллагаа явуулж эхэлсэн цагаас хойш анх удаа хугацаа алдсан гэмтэл гаргалгүй ажилласан үзүүлэлт боллоо.
- Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан компанийн аюулгүй ажиллагааны сургалтын систем, арга зүйг шинэчилж, цахимд суурилсан сургалтын шинэ төрлийн хувилбаруудыг илүү сайжруулан боловсруулсан.
- Халдвараас нийт ажилтнуудаа хамгаалах зорилгоор Гамшгаас хамгаалах штаб мэргэжлийн өндөр түвшинд ажиллаж, нийт ажилтнуудын 99.9% нь урьдчилан сэргийлэх вакцины 1, 2 дугаар тунд, нийт ажилтны 93.4% нь дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдаж, ажилтнуудаа тодорхой давтамжтайгаар түргэвчилсэн тестэд хамруулан ажилласан.

ХАБ-ЫН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2019	2020	2021
Нийт ажилласан хүн цаг (сая)	9.2	9.1	5.9
Эндэгдэл	0	2	0
Нийт гэмтлийн давтамж	2.64	1.64	1.01
Хугацаа алдсан гэмтлийн давтамж (LTIFRs)	0.66	0.55	0.00
Хууль, журамд нийцэж ажилласан байдал	+90%	+93	+93%
ХАБ-ын сургалт, зааварчилгаанд хамрагдсан хүн	14,454	12,900	7,850

АЖЛЫН БАЙРНЫ ЭРҮҮЛ АХУЙ

Ажлын байрны эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар жил бүр хийлгэж, үүнд үндэслэн төлөвлөгөө гарган ажиллаж, эрсдэлтэй ажлын байрны орчин, ажиллах нөхцлийг сайжруулах, сөрөг хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах талаар арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Бидний сар болгон хийгддэг ажлын байрны хэмжилт, мониторингийн дүн нь эрүүл ахуйн стандарт шаардлагыг ханган ажиллаж байгааг илэрхийлж байна. Тайлант онд нийт бүртгэгдсэн аюул болон үл тохирлын 95, мэдээлэгдсэн аюулын 95 хувийг тус тус арилгасан байна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН БҮСИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Цогтцэций сумын Онцгой байдлын албатай байгуулсан “Онцгой байдлын үед хамтран ажиллах гэрээ”-ний хүрээнд шаардлагатай үед онцгой байдлын бүсэд тусламж үйлчилгээ үзүүлэн хамтран ажилласаар ирсэн. Цогтцэций сумын Аврах, гал унтраах 44-р анги болон компанийн аврах бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор хамтарсан дадлага, сургалт хийж туршлага солилцсон.

Тайлант хугацаанд сумын хэмжээнд гарсан гал түймэр, осол аваар, байгалийн аюулт үзэгдэл болон Ковид-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, хүний амь нас, байгууллага, аж ахуйн нэгжийн эд хөрөнгийг аврах хамгаалахад тухай бүр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллалаа.

Онцгой байдлын нэгж нь цар тахлын үед бүрэн бүрэлдэхүүнээр бэлэн ажиллаж, ээлж хүлээн авах, солих, ажлын байр, машин техник, ажиллагсдын байрны ариутгал зэрэг ажлыг Гамшгаас хамгаалах штаб болон Хөдөлмөрийн эрүүл мэндийн нэгжтэй хамтран зохион байгууллаа. Гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хэрэгжиж байгаа журмуудыг олон улсын NFPA стандартын шаардлагын дагуу сайжруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна.

ISO СТАНДАРТ

Ухаа худаг уурхай нь Монголоос анх удаа Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны OHSAS 18001:2007 стандартуудыг цогцоор нь нэвтрүүлсэн. Уул уурхайн салбарт олон улсын ISO стандарт цогцоор нэвтэрснээр бүтээмж, засаглал, бүтээгдэхүүний чанар гээд бүх талаас олон улсад хүлээн зөвшөөрөгдөх давуу талтай. Стандартуудын хэрэгжилтийг тогтмол хянаж, магадлаж явах шаардлагатай байдаг.

Тайлант онд Менежментийн тогтолцооны хэрэгжилтийг хянах дахин баталгаажуулалтын гурав дахь шатны аудитыг “Монсерфт” ХХК-ийн аудитуудаар баталгаажуулахад бэлтгэн ажиллалаа. Энэ удаа бид ХАБЭА-н ерөнхий шаардлага, удирдлагын тогтолцооны “OHSAS 18001-2007” стандартаас ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны “ISO 45001-2018” стандарт руу шилжин, тогтолцоогоо улам сайжруулан ажиллаж байна. Уул уурхайн салбарт олон улсын ISO стандартууд цогцоор нэвтэрснээр үйлдвэрлэлийн бүтээмж, чанар сайжрах бөгөөд хариуцлагатай уул уурхай төлөвших гол ач холбогдолтой юм. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Ковид-19 цар тахлын үед аюулгүй ажиллах заавар” ISO/PAS 45005:2020 стандартыг Англи хэлнээс орчуулж гарын авлага болгон үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллахаас гадна, бусад аж ахуйн нэгж байгууллагуудад түгээж ажиллалаа.

АУДИТ БА ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН БАЙДАЛ

Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хөдөлмөрийн нөхцлийг тодорхойлох, нийт ажиллагсдад ХАБЭА-н сургалтыг зохион байгуулах, ажлын байрны үзлэгийг тогтмол хийж зөрчлийг арилгуулах, ослын судалгааг хийх гэх мэт ажлууд тогтмол хийгддэг.

2021 оны хувьд ажлын байрны төрөл бүрийн байршилд нийт 221 удаа ажлын байрны аюулгүйн үзлэг зохион байгуулж илэрсэн дутагдал зөрчлийг арилгах шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажилласан. Түүнчлэн дулааны болон орчны хүчин зүйлс, дуу шуугиан, гэрэлтүүлэг, чичиргээ, агаар дахь ерөнхий болон жижиг тоосонцор, агаар мандалд байгаа хүчилтөрөгч болон бусад хорт хийн түвшин, хэт их дуу чимээ, биеийн чичиргээ зэрэгт хөдөлмөрийн аюулгүй байдлын бүхий л нөхцөлд хяналт тавин ажиллалаа. Мөн ажлын байран дахь гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 432 удаа хийжээ.

Уурхайн үйл ажиллагаа нь дотоод хяналт, шалгалтаас гадна төрийн байгууллага, мэргэжлийн байгууллагуудын хяналт шалгалтад тогтмол хамрагддаг. Тайлант онд төрийн эрх бүхий дараах байгууллагууд хяналт шалгалт хийж, үнэлгээ дүгнэлт өгсөн байна.

- Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хийсэн шалгалтаар эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлж, хяналтын хуудасны 100 онооноос 93 оноо өгсөн.
- Онцгой байдлын ерөнхий газраас галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хяналт шалгалт хийж, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэллээ.
- Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын үндэсний төвөөс манай сургалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 100 онооноос 100 оноо өгчээ.

Хяналт шалгалтад уурхайн үйл ажиллагаа, химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдал зэрэг 154 чиглэлийг хамруулсан бөгөөд засч залруулах арга хэмжээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг 100 хувь шалгаж дүгнэсэн байна.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Манай улсад Ковид-19 цар тахлын дотоодын халдварын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш цар тахлын үед ажиллах эрсдлийн үнэлгээг хийж, компанийн дүрэм, журамд холбогдох өөрчлөлтийг хийж, шинэ журам боловсруулан мөрдөн ажиллаж эхэлсэн. Ухаа худаг уурхайн хэмжээнд Гамшгаас хамгаалах штаб байгуулан эрсдлийн цогц менежмент төлөвлөгөөг боловсруулан, нийт ажиллагсдад мөрдүүлэн ажилласан.



Олон улс болон Монгол Улсад Ковид-19 цар тахлын халдварын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээг компанийн хэмжээнд хэрэгжүүлэн, нийт ажилтан болон тэдний гэр бүлийг халдвар хамгааллаас сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах үүднээс олон ажлуудыг санаачлан хийж гүйцэтгэв. Тухайлбал:

- Ажиллагсдаа цахимаар буюу гэрээсээ ажиллах нөхцлийг бүрдүүлсэн.
- Ажилчдын амрах байрыг тусгаарлалтын байранд тавигдах шаардлагын дагуу бэлдэж, тусгаарлалтын ажлыг зохион байгууллаа.
- УОК, АОК, СОК, бусад аймгуудын онцгой комисстой цахимаар болон утсаар харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллав.
- Халдварт цар тахлын нөхцөл байдалд УОК, АОК, СОК-ын тушаал, шийдвэрийг мөрдөн, Ковид-19 цар тахлын үеийн журмын дагуу Улаанбаатар хот болон бусад орон нутгаас 58 удаагийн ээлж татан авалтаар давхардсан тоогоор 2,106 ажилтныг татан авчээ.
- Голомтын ариутгал халдваргүйтгэлийг 233 удаа зохион байгууллаа.
- Гамшгаас хамгаалах үндсэн төлөвлөгөөний дэд төлөвлөгөө болох Ковид-19 цар тахлын үед ажиллах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн ажиллав.
- Ковид-19 цар тахлын үеийн тусгаарлалтын дүрэм, журмыг хангасан тусгаарлалтын байрыг бэлдэж, үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Нийт ажиллагсад өдөр тутмын хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдаж, зайнаас халуун хэмжилт, цаг тутмын ариутгал халдваргүйжүүлэлт, хүн хоорондын зай барилт, зөвлөмж мэдээллийг тогтмол мөрдүүлэн хэвшүүлсэн. Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор “Бодь даатгал” компанитай хамтран хэрэгжүүлдэг эрүүл мэнд, осол гэмтлийн ажилтны даатгалын гэрээнд Ковид-19-ийн даатгалын багцыг нэмэлтээр оруулсан.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нийт 2.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Нийт ажилтнуудаа Ковид-19 халдвараас сэргийлэх, урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад шуурхай хамруулав.

Нийт ажилтнуудаа ажилд гарахын өмнө болон долоо хоног тутам, мөн шаардлагатай тохиолдолд түргэвчилсэн тест шинжилгээнд хамруулж, 2021 онд 3,9302 ажилтныг (давхардсан тоогоор) хамруулсан байна.

Бид гамшгаас хамгаалах бүхий л боломжит хариу арга хэмжээг авч хэрэгжүүлснээр компанийн хэмжээнд халдарт өвчин тархахаас урьдчилан сэргийлж, тархалтыг ажлын байран дээр гаргахгүй байх нөхцлийг бүрэн бүрдүүлсэн бөгөөд ажилчид халдварт өвчинд өртөх эрсдэлээс хамгаалсан үр дүнтэй арга хэмжээ болсон юм.

Ковид-19 цар тахлын үед зөвхөн Өмнөговь аймгийн харъяат орон нутгийн ажиллагсдаа ажиллуулснаар ростер сунаж ажиллагсад гэр орноосоо хол ажиллах шаардлага үүсээгүй, хөл хорионд ороогүй зэрэг олон эрсдлээс урьчилан сэргийлж чадсан. Энэ нь ажиллагсдаа орон нутагт гэр бүлээр нь шилжин суурьшуулж, тогтвортой ажиллуулах бодлого баримталж ажиллаж ирсний үр дүн юм. Ингэснээр бид цар тахлын тодорхойгүй, хүнд сорилт бүхий нөхцөл байдалд ч үйл ажиллагааныхаа тасралтгүй байдлыг ханган ажилласан.



СУРГАЛТ ЗААВАРЧИЛГАА

Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, Ухаа худаг уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн систем, хамгаалах хэрэгслийг ашиглах, цахилгааны аюулгүй ажиллагаа, онцгой нөхцөл байдлын журмууд, ослын менежмент, эрсдлийн менежмент болон анхны тусламжийн сургалтууд тогтмол хийгддэг.

Тайлант хугацаанд нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчид болон зочид гэх мэт нийт 7,850 хүнд хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлийн тусгай материал танилцуулах сургалтыг хүргэж, үүнд нийт 46,928 хүн/цаг зарцуулсан байна.

2021 онд Ковид-19 халдварын үед уурхайн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн үргэлжлүүлэх, ажилтнуудын ядаргаа, хөл хорионы үеийн стрессээс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, тэдний сэтгэл санааг дэмжих агуулга бүхий цогц мэдлэг мэдээлэл, санамж, зааварчилгаа өгөх арга хэмжээг авсан. Мөн мэргэжлийн байгууллагаас ирсэн Ковид-19-ийн үед сургалт зохион байгуулах шаардлага, зөвлөмжийн хүрээнд, цахим платформд суурилсан сургалт зааварчилгааг төслийн талбайн хэмжээнд зохион байгуулж ажилласан байна.

VIII. ШИНЭ ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ

ҮНЭТ ЗҮЙЛ

Орчин үеийн өндөр үр өгөөжтэй техник технологи нь Монгол Улсад хөгжил дэвшил авчирна гэдэгт бид итгэдэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн түвшний нүүрсний уурхай байгуулж хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын нүүрс олборлолтын салбарт техникийн шинэ стандарт тогтоохыг зорино.

Хэдийгээр улс орон даяар цар тахлын нөхцөл байдалтай, үйл ажиллагааны хувьд хүндрэлтэй байсан хэдий ч манай компани өнгөрсөн жилийн хугацаанд шинэ технологи, бүтээмж сайжруулалт, хөдөлмөрийн аюулгүй байдлын сайжруулалт, эрсдлийг хязгаарлах чиглэлд багагүй хөрөнгө оруулалт хийж, олон бодитой ажлыг хийж хэрэгжүүлсэн.

ЧИНГЭЛЭГТ ТЭЭВРИЙН ТЕРМИНАЛ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эдийн засгийг сэргээх, нүүрсний экспортыг эрчимжүүлэх, хилийн боомтуудын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминалыг байгуулах Засгийн газрын 185-р тогтоол 2021 оны долдугаар сард батлагдсан. Энэ дагуу нүүрсний экспортын гол суваг Гашуунсухайт боомтод чингэлэгт тээврийн нэмэлт терминал байгуулах төслийн гүйцэтгэгчээр манай компани төртэй хамтран ажиллаж, нийт 30 га талбайд терминал байгуулах ажлыг хоёр сарын хугацаанд шуурхай барьж дуусгаж, 2021 оны 9-р сард улсын комисст хүлээлгэн өглөө.

Уг терминалыг барьж байгуулахтай холбоотой санхүүжилтийг бид “Эрдэнэс Таван Толгой” ХК, “Тавантолгой” ХК компаниудтай хамтран хариуцсан. Манай компанийн хувьд зам, талбай барилга байгууламж зэргийг бүтээн байгуулж, уг төсөлд нийтдээ 40.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Чингэлэгт тээврийн терминал байгуулагдсанаар боомтын үйл ажиллагаанд оролцох хүн хоорондын шууд харилцаа багасч, нүүрсний тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчинд учирч буй сөрөг нөлөөлөл буурахын зэрэгцээ нүүрсний экспортын хэмжээ нэмэгдэх олон ач холбогдолтой.



Гашуунсухайтад шинээр байгуулсан чингэлэгт тээврийн терминалын ажилт

ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХЫН ТӨСӨЛ

Энержи Ресурс компани нь салбартаа анхлан, MNS 6458:2014 стандартын шаардлагад нийцсэн, 2.4 тэрбум төгрөгний өртөгтэй химийн бодис хадгалах зориулалт бүхий агуулахын барилга угсралтын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, ашиглаж байна. Химийн бодис хадгалах зориулалтын агуулахыг барьж, ашиглалтад оруулснаар химийн бодисын хадгалалттай холбоотой болзошгүй эрсдлээс сэргийлж байгаа бөгөөд Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйл ажиллагааны найдвартай байдлыг сайжруулахад чухал алхам болсон.

ТООС СОРОХ ТӨХӨӨРӨМЖ

Уурхайн нүүрс баяжуулах үйлдвэр тэжээл авч ажиллахад дотор үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор нийт 900 сая төгрөгний өртөг бүхий Dust separator тоос сорогч төхөөрөмжийг суурилуулсан. Уг төхөөрөмжийг үйлдвэрийн удирдлагын өрөөнөөс удирдах бүрэн боломжтой бөгөөд автоматчлагдсан тоноглол юм. Уг тоос сорогч төхөөрөмжийг суурилуулсны дараа нарийн ширхэглэлтэй тоосонцор хэмжигч багажаар тоос сорогч ажиллах болон зогсох үед хэмжилт хийхэд тоосны хэмжээ 50-58.3%-иар буурсан үзүүлэлттэй байв.

ҮЛ ХӨЛДӨХ ШИНГЭНИЙ БАЙГУУЛАМЖ

Өвлийн улиралд нүүрс тээвэрлэлтийн явцад хүнд даацын автомашины чиргүүлийн дотор талд нүүрс наалдаж, хөлддөг ба нүүрсийг буулгах үед гар ажилбар их шаарддаг, хүн гэмтэж, бэртэх аюултай байдаг. Энэ ажлыг хөнгөвчилж чиргүүлийн дотор талд үл хөлдөх шингэн цацдаг хоёр байгууламжийг нийт 159 сая төгрөгний өртгөөр Ухаа худаг болон Цагаан хадны нүүрс ачиж, буулгах талбайд шинээр барьж, ашиглалтад орууллаа.

АВТОМАТ АРИУТГАХ БАЙГУУЛАМЖ

Экспортын нүүрс тээврийн тээврийн хэрэгслийг ариутгах автомат дөрвөн байгууламжийг шинээр ашиглалтад оруулсан нь Ковид-19 өвчний тархалтаас хамгаалахын зэрэгцээ хүний хөдөлмөр хөнгөвчилж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулсан бодитой ажил болсон.

ШАГНАЛ

Тайлант онд хэдийгээр цар тахалтай холбоотой сорилт, эдийн засгийн хүндрэлүүд үүсч байсан ч Энержи Ресурс компанийн хувьд улс орны эдийн засагт бодитой хувь нэмэр оруулсаар байсан бөгөөд томоохон татвар төлөгч, ажил олгогчийн байр сууриа хадгалсныг төрийн болон холбогдох байгууллагуудаас өндрөөр үнэлж, талархал хүлээлээ.

ОНЫ ОНЦЛОХ АЖ АХУЙН НЭГЖ

Монгол Улсын Засгийн газар болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран жил бүр уламжлал болгон тодруулдаг Монгол Улсын ТОП-100 аж ахуйн нэгжийг шалгаруулах үйл ажиллагаа цар тахалтай холбоотой хоёр дахь жилдээ цахимаар зохион байгуулагдлаа.

Бизнесийн байгууллагуудын улсдаа оруулсан бодит хувь нэмрийг үнэлж, дүгнэдэг энэхүү шалгаруулалтад үндэсний уул уурхайн Энержи Ресурс компани Монгол Улсын нийгэм, эдийн засагт хамгийн өндөр хувь нэмэр оруулсан ТОП-100 аж ахуйн нэгж шалгаруулалтын эхний тавд дахин бичигдлээ. Үүнд, 2021 оны борлуулалт, татвар төлөлт, нийгмийн даатгалд хамруулсан ажиллагсдын тоо зэрэг гол үзүүлэлтүүдээр хувийн хэвшлийн тэргүүлэгч аж ахуйн нэгжийн байр сууриа хадгалсан байна. Бид 2009 оноос хойш ТОП-100 ААН-д нийт арав гаруй удаа шалгарснаас тогтмол эхний тавд эрэмбэлэгдэгдсээр ирсэн.

ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ АЖ АХУЙН НЭГЖ

Татварын Ерөнхий Газраас Монгол Улсын тухайн оны Шилдэг татвар төлөгчдийг зарлахад, Энержи Ресурс компани эхний тавд эрэмбэлэгдлээ. Цар тахлын хүнд хэцүү үед улсын төсвийн орлогыг бүрдүүлэхэд бодитой хувь нэмрээ оруулсан, татвар хураамжуудыг цаг тухайд нь төлж улс орны өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай биелүүлсэн гэдэг утгаараа Монгол Улсын шилдэг татвар төлөгч аж ахуйн нэгжээр арав дахь жилдээ дахин шалгарлаа. Энэхүү шалгаруулалтыг Татварын Ерөнхий Газраас жил бүр зохион байгуулж, шилдэг татвар төлөгчдөд талархал илэрхийлдэг билээ.



Энэхүү тайланд Энержи Ресурс/ Mongolian Mining Corporation групп компанийн хэмжээнд нийт охин компаниудын тоо баримт, дүн нэгтгэлүүд ашиглагдсан болно.